

Шүүхийн байгууллагын үүсэл

1927-5-20-онд Засгийн газрын 19-р тогтоолын 5 дугаар зүйлээр Улаанбаатар хотын шүүх таслах газрыг байгуулахад даргыг захиргааны даргад хавсруулсныг өөрчилж шүүхийн даргаар Жамсранг томилжээ

1927-7-13-анд “Шүүн таслах газруудад аливаа тухай” хуулийг улсын бага хурлын тэргүүлэгчдийн хурлаар батлахад уг хуулийн 66 дугаар зүйлд өмгөөлөгч ньтэр үед төлөөнөө зөөлдөгч гэсэн нэртэй байв.

1941-8-1-энд Сайд нарын Зөвлөлийн 39-р хурлын 1-р зүйлээр Шүүх явдлын яамны дүрмийг шинэчлэн батлахад түүний дотоод аппаратад нотариатын анги гэж батлагдсан байна.

Улаанбаатар хотын шүүх хуулиар харьяалуулсан анхан шатны шүүн таслах ажлын зэрэгцээгээр 1958 оноос эхлэн давж заалдах, 1962 оноос эхлэн хяналтын шатны шүүн таслах ажлыг хариуцан биелүүлэх болов.

1964-12-18-энд Сайд нарын Зөвлөлийн 554 дүгээр тогтоолд улсын нотариатын байгууллагын үйл ажиллагааг нэгтгэн удирдах явдлыг улсын дээд шүүхэд төвлөрүүлж байгаа гэж тэмдэглэжээ.

Мөн тогтоолын 6 дугаар зүйлээр мөн шүүх таслах газрын даргыг хотын захиргааны даргад хавсруулах төлөөлөгч 2, нарийн бичгийн дарга, туслах түшмэл, байцаагч түшмэл, хятад орчуулагч, морин цагдаа 2, явган цагдаа 2-оор орон тогтсон.

1965-6-30-анд Сайд нарын Зөвлөлийн 243 дугаар тогтоолоор өмгөөлөх байгууллагын дүрэм, зааврыг шинэчлэн батлахад “БНМАУ-ын өмгөөлөх байгууллагыг улсын дээд шүүхийн дэргэд зохион байгуулна” гэжээ.